

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР НУТГИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2014 онд авлигын эсрэг хийсэн ажлын тайлан /хураангуй/

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хууль дээдлэх ёсыг бодитой хэрэгжүүлж, төрийн албан хаагчдыг сонирхлын зөрчил, авилгад өртөхгүй байх, урьдчилан сэргийлэх эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг авч, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хөнгөн шуурхай хүргэх, мэдээллийг ил тод байлгах үүднээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

НЭГ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БОЛГОХ

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Удирдлагын зөвлөлийн хурлын үйл ажиллагааг тогтмол болгон, хуралдааны ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд ил тод хүргэдэг болсон. Нийслэлийн удирдлагаас гарч байгаа шийдвэрүүдийг ил тод болгох ажлын хүрээнд байгууллагын цахим хуудасны бүтцийг шинэчлэн хөгжүүлж, НИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, нийслэлийн төсвийн тайлан, албан тушаалтнуудын гадаад томилолтын тайлан, тенедерийн мэдээллийн тайлан, өргөдөл гомдлын тайланг мэдээлэхээс гадна, төрийн үйлчилгээ, харьяа байгууллагуудын мэдээлэл, өдөр тутмын болон цаг үеийн мэдээллүүдийг шуурхай мэдээлж байна.

Нийслэлийн тухайн оны батлагдсан төсвийн дэлгэрэнгүй танилцуулга номын файлыг www.ulaanbaatar.mn цахим хуудасны шилэн данс булангийн төсвийн мэдээлэл буланд байрлуулан мэдээлдэг болсон.

2012 онд www.ulaanbaatar.mn цахим хуудсанд өдөрт дунджаар 50-60 хүн ханддаг байсан бол 2014 онд давхардсан тоогоор өдөрт 30-40 мянган хүн хамрагдан нийслэлийн удирдлагуудын шийдвэр, үйл ажиллагаатай цаг алдалгүй танилцаж байна.

Нутгийн захиргааны байгууллагуудын цахим хуудсанд ил тод байдал буланг нээж,

- үйл ажиллагааны ил тод байдал;
- хүний нөөцийн ил тод байдал;
- төсөв, санхүүгийн ил тод байдал;
- төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг мэдээлж байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг 6 эх үүсвэрээр хүлээн авч, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавих бүхий л үйл ажиллагаа цахим системээр явагдаж, иргэд хяналт тавих, мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн.

Улаанбаатар хотын удирдлагын үйл ажиллагааг автоматжуулах, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор SMART UB, UB CONSTRUCTION аппликейшнуудыг үйлчилгээнд нэвтрүүлсэн. Дээрх 2 аппликейшн бий нэвтэрснээр Нийслэлийн Засаг даргын захирамж, нийтийн тээвэр, авто зам, хаяг байршил, барилга, авто замын ажлын цогц мэдээлэл түгээх үйл ажиллагаа илүү боловсронгуй болж иргэд цаг хугацаа орон зайнаас үл хамааран мэдээлэл хүлээн авах боломжтой болсон.

Нийслэлийн иргэдэд төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх, тэдний санал хүсэлтийг утсаар авах үйл ажиллагааг тогтмолжуулж “Лавлагаа мэдээллийн төв” /Call Center/-ийг ажиллуулж байна. Дээрх төв өнгөрсөн хугацаанд 130.349 дуудлага хүлээн авч үйлчилсэн байна.

Барилгын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хялбарчлах үүднээс барилга, газар олголттой холбоотой техникийн зөвлөлийн хурлын шийдвэрийг нээлттэй болгосон. Өмнө нь барилга барих зөвшөөрлийг авахад 61 гарын үсэг зуруулж 107 хоногт олгодог байсныг нэг цэгт төвлөрүүлэн 17 хоногт багтаан шийдвэрлэдэг болсон.

Нийслэлийн Засаг дарга иргэдтэй уулзах уулзалтыг тогтмолжуулж, 7 хоног бүрийн Баасан гарагт иргэдийг хүлээн авч уулзан тулгамдсан асуудлыг нь шийдвэрлэдэг боллоо. Нийт 40 удаагийн уулзалтаар 417 иргэнийг хүлээн авч уулзан, санал, хүсэлтийг нь шийдвэрлэсэн байна.

Төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх үүднээс төрийн зарим үйлчилгээг хороонд шилжүүлэв. 2014 онд иргэний бүртгэлийн 9 төрлийн үйлчилгээг нийслэлийн 90 хороонд шилжүүлж үйлчилгээг иргэдэд ойртуулсан. Цаашдаа 62 хороонд иргэний бүртгэлийн үйлчилгээ болон бусад төрийн үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Нийслэлийн газар өмчлөлийн асуудлыг цахим хэлбэрээр зохион байгуулах ажлыг санаачлан анх удаа зохион байгууллаа. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэдэд өмчлүүлэх 159'309 га газрын 52 байршлыг тогтоож 2014 оны 8 дугаар сард цахимаар сонгон шалгаруулсан. Цахим хэлбэрээр газар өмчлөх хүсэлтэй 281.440 иргэн бүртгүүлснээс 14.954 иргэн газар өмчлөх эрхтэй болсон.

Нийслэлийн хэмжээнд 14 байгууллагаас 96 зөвшөөрөл олгож байгаа бөгөөд Нийслэлийн Засаг дарга аж ахуй үйл ажиллагаа эрхлэх 5 төрлийн тусгай зөвшөөрлийг олгож байна. Засгийн газраас бүх төрлийн зөвшөөрөл, лицензийн тоог зохистой хэмжээнд бууруулах ажлын хүрээнд “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн барьсан. Энэ хууль батлагдсанаар нийслэлээс олгогдож байгаа зөвшөөрлийн тоо буурч, авлига хүнд суртал багасах боломжтой юм.

ХОЁР. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООГ ШИНЭЧЛЭХ

Улаанбаатар хотын өдөр тутмын амьдралыг зохицуулсан, оршин суугчид руугаа чиглэсэн, нийтийн эрх ашигт нийцсэн, иргэдийн эрүүл, аюулгүй, тав тухтай оршин суух орчныг бүрдүүлэх зорилгоор Улаанбаатар хотын багц дүрмийг 2 жилийн

өмнөөс боловсруулж эхэлсэн. Одоогийн байдлаар хотын үндсэн дүрэм, 58 салбар дүрмийг бий болгон гаргасан.

Мэдээллийн ил тод байдлыг хангах, авлигаас ангид байх зорилгоор мэдээллийн ил тод байдлыг хангах тухай журам, нийслэлийн удирдлагаас иргэдтэй хийх уулзалтыг зохион байгуулах журам, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх журам, захирамжлалын баримт бичиг батлах, хянах, мэдээлэх журам, газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх, хугацааг сунгах газрын зориулалтыг өөрчлөх үйл ажиллагааны журам, барилга угсралтын үйл ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангах асуудлыг зохицуулах нийтлэг журам зэрэг нийтээр дагаж мөрдөх журмуудыг батлан мөрдөж байна.

Төрийн үйлчилгээг цахимжуулах Техник эдийн засгийн үндэслэлийг хувийн хэвшлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлж байна. Энэхүү ажилд шаардлагатай хөрөнгийг Төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж байна.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа 536 нэр төрлийн төрийн үйлчилгээний судалгааг нэгтгэн боловсрууллаа. Төрийн үйлчилгээний судалгаа болон Төрийн үйлчилгээг цахимжуулах Техник эдийн засгийн үндэслэл зэрэг судалгааны баримт бичгүүдийг ашиглан төрийн үйлчилгээг цахимжуулах ажлыг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

ГУРАВ. ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ИРГЭДИЙН САНАЛЫГ ТУСГАХ

Нийслэлийн иргэдийн саналыг сонсох, тэдгийг саналыг нийслэлийн удирдлагаас гарч байгаа шийдвэрүүдэд тусгах зорилгоор 9 дүүрэг, 78 хороонд иргэний танхимыг шинээр байгуулсан. Иргэний танхимаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх ажил, Иргэдийн амьдрах орчны зураглал “Иргэдийн оролцоотой төсөв-2014”, Хороодын амьдрах орчин, аж байдлын зураглал зэргийг хэлэлцэн иргэдээс гарсан саналыг удирдлагын түвшинд хэлэлцэж шийдвэр гаргалаа. Түүнчлэн нийслэлд анх удаа 2014 оны төсвийг батлахдаа иргэдийнхээ саналыг авч, төсвийн төсөлд тусгасан.

ДӨРӨВ.АВЛИГЫН ЭРЭГ ТӨЛӨВЛӨГӨӨ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

НЗД-ын 2014 оны А/179 дүгээр захирамжаар Авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөг батлан дүүрэг хэрэгжүүлэгч агентлагуудад хүргүүлсэн. Дүүрэг хэрэгжүүлэгч агентлагууд нь өөрийн авлигын эсрэг төлөвлөгөөг батлан ажилласан.

Авлигатай тэмцэх газар, Азийн сантай хамтран “Сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлж, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх төслийн ажлын төлөвлөгөөг баталсан. Нийслэлийн Боловсролын газар, Эрүүл мэндийн газар, Ерөнхий төлөвлөгөөний газар, Өмчийн харилцааны газар дээр дээрх төсөл 2013 оны 09 дүгээр сараас эхлэн хэрэгжиж байгаа бөгөөд төлөвлөгөөг эрчимжүүлэх

үүднээс 7 хоног бүр АТГ-н Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан Б.Батзориг болон холбогдох эрх бүхий албан тушаалтнуудын уулзалтыг зохион байгуулсан.

Авлигатай тэмцэх газарт 2013 оны хөрөнгө орлогын мэдүүлэг бүртгүүлэх албан тушаалтны нэрстийн жагсаалтыг хуулийн хугацаанд батлагдсан маягтын даргуу нэгтгэн хүргүүлсэн. Хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлын тайлангаар НЗДТГ, хэрэгжүүлэгч агентлаг, харьяа байгууллагын 2665 албан тушаалтан хөрөнгө орлогын мэдүүлгээ бүртгүүлсэн байна.

Нийтийн албан тушаалтнуудын увийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг мэдүүлэх хуулийн хугацаа эхэлсэнтэй холбогдуулан мэдүүлэг гаргагч албан тушаалтнууд болон, мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудад сургалт зохион байгуулсан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт мэдүүлгээ ирүүлсэн албан тушаалтнуудын 2008-2010 онуудын мэдүүлгийг архивлаж 14 боть болгосон.

Авлигатай тэмцэх газар, Азийн сантай хамтран Нийслэлийн Боловсролын газар, Эрүүл мэндийн газар, Ерөнхий төлөвлөгөөний газар, Өмчийн харилцааны газруудад сайн засаглал ил тод байдлыг нэмэгдүүлэх ХАМТДАА төслийг хэрэгжүүлсэн.

Төсөл хэрэгжснээр Улаанбаатар хотын иргэдийн анхаарлыг хамгийн их татдаг асуудлуудыг иргэдэд ойлгомжтой байдлаар шийдвэрлэсэн. Нийслэлийн газрын холбогдолтой мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор 150 орчим хорооны газрын кадастрын зураг хийж, тэдгээрээс төвийн дүүргийн 20 гаруй хорооны зургийг холбогдох мэдээллийн хамт Өмчийн харилцааны газрын цахим хуудсаар олон нийтэд ил болголоо.

Эдгээр зургууд нь төрийн өмчийн газар эзэмшилтэй холбоотой мэдээллийг олон нийтэд өгснөөр газартай холбоотой хардлага сэрдлэгэ, маргаанаас урьдчилан сэргийлэх боломжийг өгөх болно. Түүнчлэн 40000 гаруй хуудас газар өмчлүүлэх, эзэмшүүлэх шийдвэрүүдийг электрон хэлбэрт хувиргаж цахим хуудаст нийтлэж, мөн архивын байгууллагад шилжүүллээ.

Төрийн албаны шийдвэрийн ил тод байдлыг хангах зорилгоор Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн засаг дарга, түүний хэрэгжүүлэгч агентлагуудын дарга нар, 9 дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нарын шийдвэрийн нэгдсэн сангийн цахим хуудас, програм хангамжийг бүтээж, мэдээллийн баазыг бүрдүүлж байна. Өнөөдрийн байдлаар нэгдсэн санд Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, болон Засаг даргын 16000 гаруй шийдвэрийн мэдээлэл ороод байна.

Мөн дээр байгууллагуудад мэдээлэлийн 24 самбарыг байрлуулж, эдгээр байгууллагуудад ёс зүйн хороог байгуулж, чё зүйн хороон мэргэжилтнүүдийг чадавхижуулсан. Азийн сан Нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран эрүүл мэндийн салбар дахь авлигын нөхцөл байдлын судалгаа явуулсан.

Судалгааг 200 эмч, сувилагч, 700 үйлчлүүлэгчдийн дунд явуулж, үр дүнг нь 6 дүүрэг дэх Эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн 300 орчим эмч нарын дунд хэлэлцүүлсэн.

Боловсрол, шинжлэх ухааны яам, Нийслэлийн Боловсролын газартай хамтран Багшийн ёс зүйн дүрмийн төслийг шинэчлэн боловсруулж, нийслэлийн 6 дүүрэг дэх Ерөнхий Боловсролын сургуулийн багш нарын дунд 2013 оны 12, 1 сард хэлэлцүүлсэн. Түүнчлэн сургуулийн орчин дахь авлигын нөхцөл байдал, тулгарч буй асуудлыг ерөнхий боловсролын 80 сургуулийн захирлуудын дунд 2013 оны 4 сард хэлэлцүүлж, холбогдох санал зөвлөмжийг уламжиллаа. Авлигын эсрэг хуулийг нийслэлийн 12 агентлаг, 26 эмнэлгийн байгууллага, 98 сургуулийн 1400 гаруй ажилтан, албан хаагчдад сурталчилан ажилласан.

ТАВ. НЭЭЛТТЭЙ УЛААНБААТАР-2014

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилт, нийслэлийн авлигын эсрэг 2014 оны төлөвлөгөө, Улаанбаатар хотыг олон нийтэд нээлттэй, ил тод болгох, ажлыг эрчимжүүлэх, нийслэл, орон нутгийн захиргааны түвшинд авлигын эсрэг стратеги төлөвлөгөөг боловсруулах, авлигын эсрэг олон улсын сургалт, судалгааны төвийн салбарыг Улаанбаатар хотод нээх эхний алхамыг эхлүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүлийн санаачилга, Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн /IRI/, Авлигатай тэмцэх газрын дэмжлэгтэйгээр “Нээлттэй-Улаанбаатар-2014” Авлигын эсрэг олон улсын форумын анх удаа зохион байгууллаа.

Тус форумд гадаадын 17 орны 42 олон улсын байгууллагын төлөөлөгчид, гадаад улс орноос Улаанбаатар хотод суугаа Элчин сайдын яам, дипломат төлөөлөгчдийн газар, төр засгийн удирдагчид, эрдэмтэн мэргэд, судлаачид, шийдвэр гаргагчид, нийслэл, аймаг орон нутгийн засаг захиргааны байгууллагын удирдах хүмүүс, төрийн бус байгууллагуудын төлөөлөл нийт 250 гаруй төлөөлөгчид оролцсноос гадна Гадаад харилцааны яам, Азийн Ардчилалын сүлжээ, Тайваний Ардчилалын сан, Нийтлэг эрх ашгийн төв, Транспаренси Интернэшнл, Ардчилалын төлөөх дэлхийн хөдөлгөөн, Үндэсний ардчилалын сан, Олон Улсын хувийн жижиг дунд үйлдвэрлэлийн төв зэрэг гадаад дотоодын 10 гаруй байгууллагууд хувь нэмрээ оруулан хамтран ажилласан.

“Нээлттэй-Улаанбаатар-2014” Авлигын эсрэг Олон улсын форумын үндсэн илтгэлийг “Авлигад Хяналт Тавих -Институцийн Шинэчлэл ба Иргэний Нийгмийн Дайчилгаа” сэдвээр Станфордын Их сургуулийн профессор Ларри Даймонд, авлигын эсрэг нийслэлээс хийж, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа сэдвээр НЗДТГ-ын дарга Ё.Гэрэлчулуун нар тавьсан. Мөн Төр ба нийгмийн уялдаа холбоо, Газар хувиарлалт ба өмчийн бүртгэл, Худалдан авах ажиллагаа, Тусгай зөвшөөрөл гэсэн үндсэн 4 сэдвийн дор салбар хуралдааныг зохион байгуулсан. Салбар хуралдааныг нийслэлийн холбогдох ажил хариуцсан дарга нар гадаадын экспертүүдийн хамт удирдан явуулж, нийслэлийн стратеги төлөвлөгөөнд холбогдох саналуудыг тусгасан.

Авлигатай тэмцэх үйл ажиллагааг шинэ шатанд гаргах, сайн туршлага бүхий улс орнуудын туршлагыг судлах зорилгоор гадаадын байгууллага, эрдэмтэн мэргэд болон орон нутгийн засаг захиргаа, иргэний нийгмийн байгууллага, бизнесийн салбарынхан болон судлаачдыг нэг дор цуглуулж Улаанбаатар хот, бүс нутаг, олон улсын хэмжээнд хэрэгжүүлж буй авлигатай тэмцэх шинэ арга замуудыг эрэлхийлж, Улаанбаатар хот авлигатай тэмцэх үйл ажиллагаагаараа бүс нутгийн хэмжээнд манлайлж, авлигын эсрэг стратеги төлөвлөгөөг олон улсын зөвлөхүүдийн оролцоотойгоор дэлхийн жишигт нийцсэн арга зүйгээр боловсруулан хэрэгжүүлэх

зорилгоор Улаанбаатарын тунхаглал, Улаанбаатар хотын авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөөний саналыг боловсруулж гаргасан.

“Нээлттэй Улаанбаатар-2014” Авлигын эсрэг Олон улсын форумас гарсан санал санаачилгыг цааш хэрэгжүүлж ажиллах үүднээс “Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр”-ийг боловсруулан НИТХ-аар хэлэлцүүлэхэд бэлэн болоод байна. Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 7 зорилт бүхий стратеги төлөвлөгөөг төслийн шатанд боловсруулан 2014-2016, 2016-2020 он гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
НУТГИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС-2014